БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БНА-2020/38/СТА-ТШЗ**


Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер: А.Цээням
Утас: 88089024 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn
Аудитор: П.Амаржаргал
Утас: 99890393 Цахим хаяг: amaraa_802002@yahoo.com
Цахим хуудас: www.audit.mn


Баянхонгор
2020 он

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

Агуулга

**Аудитын гэрчилгээ** ........ 3
Аудитын тайлан ........ 5
2.1. Оршил ........ 5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ........ 5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт ........ 5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ........ 6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ........ 6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ........ 7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ........ 7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ........ 7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ........ 8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ........ 9
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ........ 9
2.13. Шилэн дансны мэдээлэл ........ 9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт ........ 9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл ........ 9
Менежментийн захидал ........ **Error! Bookmark not defined.**
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан ........ 10
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан ........ 10
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 11
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 13
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 14
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 15
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ........ 17

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2020.02.06 № 2/49

танай ____________ -ны №____________ -т

ГБАЯНХОНГОР АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ А.ЦЭЦЭНБИЛЭГ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл,санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж

Тоот-А4

005020010

байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД
АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦЭЭНЯМ

Тоот-А4

## 2.1. Оршил

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга барилга хот байгуулалтын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Цэцэнбилэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга барилга хот байгуулалтын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга барилга хот байгуулалтын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 28-наас 2020 оны 02 дугаар сарын 03-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Амаржаргал хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга барилга хот байгуулалтын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 1/19 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга барилга хот байгуулалтын газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь "Байгууллагын үйл ажиллагаа нь газрыг геодези, зураг зүйд үндэслэн иргэн хуулийн этгээдэд эрх зүйн баталгаатайгаар эзэмшүүлэх ашиглуулах гагцхүү Монгол Улсын иргэнд өмчлүүлэх улмаар газрыг сонгодог утгаар нь эдийн засгийн эргэлтэнд оруулах барилга хот байгуулалтын талаар төрөөс баримталж буй бодлогыг орон нутагт хэрэгжүүлж, хот төлөвлөлтийг боловсронгуй болгох, хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх хүн амын ая тухтай орчинд ажиллаж амьдрах нөхцлийг хангахад чиглэгдсэн үйл ажилллаагаа явуулж хууль тогтоомжийн хэрэгжилтэнд тавих хяналтын үр нөлөөг сайжруулахад чиглэгдэнэ" оршино.

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга барилга хот байгуулалтын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын чиглэлээр төрийн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх
- АГЗБТөлөвлөгөө боловсруулах түүнд нийцүүлэн хот байгуулалтын төлөвлөгөөний дагуу газар эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэх ажлыг зохион байгуулах
- Улсын болон ОНутгийн хувийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа барилга байгуулжинд их засварын ажилд техникийн болон захиалагчийн хяналт хийх
- Барилгын материалудад лабораторийн сорилт шинжилгээ хийж баталгаажуулах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль
- Газрын харилцаа, барилга барилга хот байгуулалтын тухай хууль

## 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга барилга хот байгуулалтын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга барилга хот байгуулалтын газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд "Санхүүгийн тооцоолох груп" ХХК-ийн "Acolous" программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга барилга хот байгуулалтын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга барилга хот байгуулалтын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 35 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2.0 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 760790,9 мянган төгрөгөөс тооцон 15215,8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 15215,8 мянган төгрөгөөр тооцсон нь улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзсэнтэй холбоотой юм.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга барилга хот байгуулалтын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 25919,83 мянган төгрөгөөр буюу 1,8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **34,271.03** | **36,383.04** | **2,112.01** |
| 33 | **АВЛАГА** | 118.73 | 00.00 | -118.73 |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | 34,152.30 | 36,383.04 | 2,230.74 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **332,882.91** | **304,851.07** | **-28,031.84** |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 332,882.91 | 304,851.07 | -28,031.84 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **367,153.94** | **341,234.11** | **-25,919.83** |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **367,153.94** | **341,234.11** | **-25,919.83** |
| 51 | **Засгийн газрын хувь оролцоо** | 367,153.94 | 341,234.11 | -25,919.83 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **367,153.94** | **341,234.11** | **-25,919.83** |

Авлага өмнөх оноос 118,7 мянган төгрөгөөр буурч, авлагагүй гарсан нь өмнөх оны авлагын мөнгийг дансанд тайлант оны НДШ-ын тооцоонд суутгат тооцож авлагыг барагдуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 2230,7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 2019 онд Бусад хангамжийн материалын зардалд ГЗБГГГ-аас үнэ төлбөргүй 14637,6 мянган төгрийн бараа материалыг орлого авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 32027,9 мянган төгрөгөөр нэмэгдсэн ба энэ нь 2019 онд төсвийн хөрөнгөөр 27027,9 мянган төгрөгөөр худалдан авч, 24042,5 мянган төгрөгийн үнэ төлбөргүй үндсэн хөрөнгө нэмэгдсэн, харин 20000,0 мянган төрөгийн балансын үнэтэй УАЗ-2206 маркийн БНХ-4404 дугаартай авто машиныг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 12 дугаар сарын11-ний өдрийн 567 дугаар тогтоолыг үндэслэн актлан данс бүртгэлээс хассан байна. Тайлант онд 76241,2 мянган төгрөгийн элэгдэлийн зардал тооцсон байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 341234,1 мянган төгрөг болж 25919,8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 25919,8 мянган төгрөгийн хасах дүнтэй илэрхийлэгдсэнтэй холбоотой байна.

## 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга барилга хот байгуулалтын газар нь тайлант онд 59200,0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 59360,0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 102 хувиар биелүүлсэн байна.

*Хүснэгт 2.* Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

| Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| Үнэт цаасны орлого | 59200,0 | 59360,0 | 160,0 | 102,0 |
| **Нийт дүн** | 59200,0 | 59360,0 | 160,0 | 102,0 |

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 493649.5 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 462356.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 31292.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, Барилга техникийн хяналтын зардлаас 180541,2 мянган төгрөг, лабораторын орлогоос 14608,8 мянган төгрөгийг оруулж санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Зардлыг санхүүжүүлсэн орлогын гүйцэтгэлийг төлөвлөлттэй уялдуулан шалгахад:

Тайлант онд улсын төсвөөс авах 493649.5 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн авсан бөгөөд үйл ажиллагааны орлого 59360,5 мянган төгрөгийг бүрэн төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 493150.8 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь улсын төсвөөс 493649.5 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд зарцуулж 498.6 мянган төгрөг хэмнэгдэн төвлөрүүлсэнтэй холбоотой байна. Энэ нь ашиглалттай холбоотой зардал гэрэл цахилгааны хэрэглээтэй холбоотой хэмнэгдсэн байна.

**Нэмэлт төсөв:** Тус байгууллага нь 2018 оны ажлыг дүгнүүлэн 1-р байрт шалгаран шагнуулж Засаг даргын нөөц хөрөнгөөс 10000.0 мянган төгрөг орсон, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон БТХЗ-ын орлого 180541.2 мянган төгрөг, лабораторын орлого 14608.8 мянган төгрөг нийт 205149.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үнээс: Бараа үйлчилгээний бусад зардалд 125344.0 мянга, Шагнал урамшуулалын зардалд 10000.0 мянга нийт 135344.0 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 59506.0 мянган төгрөгийг улсын төсөвт, 10300.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

## 2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 35 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 24 эрсдэл тодорхойлж нийт 24 горим сорил хэрэгжүүллээ.

## 2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна

## 2.13. Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга барилга хот байгуулалтын газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 140 мэдээллийг хугацаанд нь, 9 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

| д/д | Хугацаа | Төрөл | Удаа | Хугацаанд оруулсан | Хугацаа хоцроосон | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 9 | | 2 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 4 | | |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 3 | 1 | |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 35 | 1 | |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 89 | 7 | |
| | Нийт | 27 | 151 | 140 | 9 | 2 |

## 2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

## 2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга барилга хот байгуулалтын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

"Зөрчилгүй" дүгнэлт

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга барилга хот байгуулалтын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

## 1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 34,271,031.42 | 36,383,039.42 |
| 33 | АВЛАГА | 118,732.00 | 00.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 118,732.00 | 00.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 34,152,299.42 | 36,383,039.42 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 55,346.00 | 55,346.00 |
| 354 | Хангамжийн материал | 34,096,953.42 | 36,327,693.42 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,204,150.00 | 1,480,750.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 7,095,486.00 | 7,397,500.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 9,365,869.00 | 2,980,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 87.42 | 1,958,072.42 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 16,431,361.00 | 22,511,371.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 332,882,910.88 | 304,851,071.02 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 332,882,910.88 | 304,851,071.02 |
| 392 | Биет хөрөнгө | 309,976,577.66 | 282,120,737.84 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 195,394,386.72 | 195,394,386.72 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -793,333.39 | -5,494,289.11 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 112,491,750.00 | 92,491,750.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -93,846,947.54 | -85,825,083.36 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 274,121,192.31 | 316,859,092.31 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -182,690,046.26 | -244,154,231.58 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 18,587,773.00 | 27,877,773.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -13,288,197.18 | -15,028,660.14 |
| 393 | Биет бус хөрөнгө | 22,906,333.22 | 22,730,333.18 |
| 39301 | Програм хангамж | 1,790,000.00 | 1,790,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,408,666.78 | -1,584,666.82 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 22,525,000.00 | 22,525,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 367,153,942.30 | 341,234,110.44 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 367,153,942.30 | 341,234,110.44 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 367,153,942.30 | 341,234,110.44 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 328,802,027.70 | 328,802,027.70 |
| 51101 | Өмч: - төрийн | 328,802,027.70 | 328,802,027.70 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | -25,454,040.67 | -51,373,872.53 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -25,454,040.67 | -25,454,040.67 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -25,919,831.86 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 63,805,955.27 | 63,805,955.27 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 367,153,942.30 | 341,234,110.44 |

### 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **516,255,445.72** | **734,871,118.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **64,493,750.72** | **21,133,900.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 64,493,750.72 | 21,133,900.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 64,493,750.72 | 21,133,900.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 61,579,560.00 | 00.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 118,732.00 | 00.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 2,795,458.72 | 21,133,900.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **49,700,995.00** | **251,080,518.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 11,009,280.00 | 00.00 |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | 11,009,280.00 | 00.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 402,060,700.00 | 462,656,700.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 32,708,508.00 | 205,150,018.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 10,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,685,000.00 | 49,881,572.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 29,023,508.00 | 145,268,446.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 00.00 | 31,292,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 00.00 | 31,292,900.00 |
| 132005 | Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/ | 2,300,000.00 | 00.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 2,300,000.00 | 14,637,600.00 |
| 133003 | Хөрөнгийн | 00.00 | 14,637,600.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 3,683,207.00 | 00.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 3,683,207.00 | 00.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **555,192,621.86** | **760,790,949.86** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **555,192,621.86** | **760,790,949.86** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 484,542,309.86 | 683,900,684.86 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 292,637,474.00 | 363,504,199.00 |
| 210101 | Үндсэн цалин | 292,637,474.00 | 363,504,199.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 35,041,926.00 | 45,600,989.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 32,054,577.00 | 40,886,008.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,987,349.00 | 3,802,081.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 243,400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 60,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 00.00 | 608,600.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 21,171,355.00 | 22,939,729.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,712,914.00 | 2,174,209.00 |
| 210302 | Түлш, халаалт | 17,033,521.00 | 18,340,560.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,424,920.00 | 2,424,960.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 8,680,087.00 | 7,957,762.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,231,800.00 | 1,572,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,434,250.00 | 4,313,115.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 547,607.00 | 555,661.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,466,430.00 | 1,516,386.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 513,600.00 | 396,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 513,600.00 | 396,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,743,231.00 | 4,260,640.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,743,231.00 | 4,260,640.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,619,600.00 | 2,953,790.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,619,600.00 | 2,953,790.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 16,714,308.00 | 96,693,863.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 16,129,708.00 | 96,139,263.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 99,000.00 | 99,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 268,900.00 | 268,900.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 216,700.00 | 186,700.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 104,420,728.86 | 139,593,712.86 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 42,827,299.86 | 63,352,473.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 61,593,429.00 | 76,241,239.86 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 70,650,312.00 | 76,890,265.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 9,070,507.00 | 6,431,000.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 3,390,300.00 | 00.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 5,680,207.00 | 2,078,400.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 3,552,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 800,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 29,805.00 | 145,544.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 29,805.00 | 145,544.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 00.00 | 10,953,171.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 10,953,171.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 61,550,000.00 | 59,360,550.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 61,550,000.00 | 59,360,550.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-38,937,176.14** | **-25,919,831.86** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-38,937,176.14** | **-25,919,831.86** |

### 4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **210,924,392.00** | **699,099,618.00** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **4,716,000.00** | **00.00** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | 4,716,000.00 | 00.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 4,716,000.00 | 00.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,716,000.00 | 00.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **206,208,392.00** | **699,099,618.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 199,241,500.00 | 462,656,700.00 |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 6,966,892.00 | 205,150,018.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 10,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 49,881,572.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 6,966,892.00 | 145,268,446.00 |
| 1320 | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 00.00 | 31,292,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 00.00 | 31,292,900.00 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **197,143,576.00** | **672,024,118.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **197,143,576.00** | **672,024,118.00** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **191,846,576.00** | **595,772,253.00** |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 138,127,186.00 | 364,100,156.00 |
| 210101 | Үндсэн цалин | 103,013,986.00 | 269,556,156.00 |
| 210102 | Нэмэгдэл | 22,704,000.00 | 72,162,300.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,934,600.00 | 9,539,985.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 6,474,600.00 | 12,841,715.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 16,625,936.00 | 45,524,700.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 16,625,936.00 | 30,954,278.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 3,642,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 2,913,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 730,822.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 00.00 | 7,284,000.00 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 11,706,917.00 | 22,939,729.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 986,407.00 | 2,174,209.00 |
| 210302 | Түлш, халаалт | 9,508,050.00 | 18,340,560.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,212,460.00 | 2,424,960.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | 3,831,848.00 | 7,741,100.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 261,900.00 | 1,145,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,920,000.00 | 4,705,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 245,545.00 | 455,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,404,403.00 | 1,434,300.00 |
| 2105 | **Нормативт зардал** | 50,000.00 | 396,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 50,000.00 | 396,000.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 299,000.00 | 8,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 299,000.00 | 8,000,000.00 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | 690,000.00 | 2,333,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210702 | Дотоод албан томилолт | 690,000.00 | 2,333,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,799,250.00 | 111,986,568.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,276,000.00 | 111,401,968.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 99,000.00 | 99,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 225,400.00 | 268,900.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 198,850.00 | 216,700.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 16,716,439.00 | 32,751,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 16,716,439.00 | 32,751,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **5,297,000.00** | **76,251,865.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 627,000.00 | 5,792,600.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 627,000.00 | 1,440,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 3,552,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 800,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 145,544.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 145,544.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 00.00 | 10,953,171.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 10,953,171.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 4,670,000.00 | 59,360,550.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,670,000.00 | 59,360,550.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | **13,780,816.00** | **27,075,500.00** |
| 5 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **00.00** | **27,075,500.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **00.00** | **27,075,500.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 00.00 | 27,075,500.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 00.00 | 27,075,500.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **00.00** | **-27,075,500.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 13,780,816.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 13,780,816.00 | 00.00 |

## 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| **Код** | **Үзүүлэлт** | **Засгийн газрын оруулсан капитал** | **Дахин үнэлгээний нөөц** | **Хуримтлагдсан дүн** | **Засгийн газрын хувь оролцооний нийт дүн** |
|---|---|---|---|---|---|
| С01 | **2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 306,277,027.70 | 2,546,417.69 | 12,912,348.68 | 321,735,794.07 |
| С02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 570,786.79 | 570,786.79 |
| С03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **306,277,027.70** | **2,546,417.69** | **13,483,135.47** | 322,306,580.86 |
| С04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| С05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| С06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| С07 | Тайлант үеийн үр дүн | 22,525,000.00 | 00.00 | -38,937,176.14 | -16,412,176.14 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| C08 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **328,802,027.70** | **63,805,955.27** | **-25,454,040.67** | 367,153,942.30 |
| D01 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **328,802,027.70** | **63,805,955.27** | **-25,454,040.67** | 367,153,942.30 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **328,802,027.70** | **63,805,955.27** | **-25,454,040.67** | 367,153,942.30 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -25,919,831.86 | -25,919,831.86 |
| D09 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **328,802,027.70** | **63,805,955.27** | **-51,373,872.53** | 341,234,110.44 |

## 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Дүн | Хувь |
|---|---|---|---|---|
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 493,649,500.00 | 493,150,885.00 | 498,615.00 | 99.90 |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | 493,649,500.00 | 493,150,885.00 | 498,615.00 | 99.90 |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 487,856,900.00 | 487,358,285.00 | 498,615.00 | 99.90 |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 364,198,100.00 | 364,100,156.00 | 97,944.00 | 99.97 |
| Үндсэн цалин | 269,654,100.00 | 269,556,156.00 | 97,944.00 | 99.96 |
| Нэмэгдэл | 72,162,300.00 | 72,162,300.00 | 0.00 | 100.00 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 10,880,100.00 | 9,539,985.00 | 1,340,115.00 | 87.68 |
| Гэрээт ажлын хөлс | 11,501,600.00 | 12,841,715.00 | -1,340,115.00 | 111.65 |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 45,524,700.00 | 45,524,700.00 | 0.00 | 100.00 |
| Тэтгэврийн даатгал | 30,956,800.00 | 30,954,278.00 | 2,522.00 | 99.99 |
| Тэтгэмжийн даатгал | 3,642,000.00 | 3,642,000.00 | 0.00 | 100.00 |
| ҮОМШӨ-ний даатгал | 2,913,500.00 | 2,913,600.00 | -100.00 | 100.00 |
| Ажилгүйдлийн даатгал | 728,400.00 | 730,822.00 | -2,422.00 | 100.33 |
| Эрүүл мэндийн даатгал | 7,284,000.00 | 7,284,000.00 | 0.00 | 100.00 |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 23,292,900.00 | 22,939,729.00 | 353,171.00 | 98.48 |
| Гэрэл, цахилгаан | 2,327,700.00 | 2,174,209.00 | 153,491.00 | 93.41 |
| Түлш, халаалт | 18,381,400.00 | 18,340,560.00 | 40,840.00 | 99.78 |
| Цэвэр, бохир ус | 2,583,800.00 | 2,424,960.00 | 158,840.00 | 93.85 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Хангамж, бараа материалын зардал** | 7,741,100.00 | 7,741,100.00 | 0.00 | 100.00 |
| Бичиг хэрэг | 1,145,500.00 | 1,145,500.00 | 0.00 | 100.00 |
| Тээвэр, шатахуун | 4,805,800.00 | 4,705,800.00 | 100,000.00 | 97.92 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 455,500.00 | 455,500.00 | 0.00 | 100.00 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,334,300.00 | 1,434,300.00 | -100,000.00 | 107.49 |
| **Нормативт зардал** | 396,000.00 | 396,000.00 | 0.00 | 100.00 |
| Нормын хувцас, зөөлөн эдлэл | 396,000.00 | 396,000.00 | 0.00 | 100.00 |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | 8,000,000.00 | 8,000,000.00 | 0.00 | 100.00 |
| Урсгал засвар | 8,000,000.00 | 8,000,000.00 | 0.00 | 100.00 |
| **Томилолт, зочны зардал** | 2,380,500.00 | 2,333,000.00 | 47,500.00 | 98.00 |
| Дотоод албан томилолт | 2,380,500.00 | 2,333,000.00 | 47,500.00 | 98.00 |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 584,600.00 | 584,600.00 | 0.00 | 100.00 |
| Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 99,000.00 | 99,000.00 | 0.00 | 100.00 |
| Даатгалын үйлчилгээ | 268,900.00 | 268,900.00 | 0.00 | 100.00 |
| Тээврийн хэрэгслийн оношлогоо | 216,700.00 | 216,700.00 | 0.00 | 100.00 |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | 35739000.00 | 35739000.00 | 0.00 | 100.00 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 35,739,000.00 | 35,739,000.00 | 0.00 | 100.00 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 00.00 | 00.00 | 0.00 | |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 5792600.00 | 5792600.00 | 0.00 | 100.00 |
| **Бусад урсгал шилжүүлэг** | 5,792,600.00 | 5,792,600.00 | 0.00 | 100.00 |
| Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 2,240,000.00 | 2,240,000.00 | 0.00 | 100.00 |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 3,552,600.00 | 3,552,600.00 | 0.00 | 100.00 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 00.00 | 0.00 | 0.00 |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 493,649,500.00 | 493,150,885.00 | 498,615.00 | 99.90 |
| **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 493,649,500.00 | 493,150,885.00 | 498,615.00 | 99.90 |
| Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 462,356,600.00 | 461,857,985.00 | 498,615.00 | 99.89 |
| **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 31,292,900.00 | 31,292,900.00 | 0.00 | 100.00 |
| Орон нутгийн төсвөөс | 31,292,900.00 | 31,292,900.00 | 0.00 | 100.00 |
| **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 36.00 | 36.00 | 0.00 | 100.00 |
| Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 0.00 | 100.00 |
| Гүйцэтгэх ажилтан | 30.00 | 30.00 | 0.00 | 100.00 |
| Үйлчлэх ажилтан | 03.00 | 03.00 | 0.00 | 100.00 |
| Гэрээт ажилтан | 02.00 | 02.00 | 0.00 | 100.00 |

### 4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **118,695,568.00** |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **118,695,568.00** |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 118,695,568.00 |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | 118,695,568.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 118,695,568.00 |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | 88200068.00 |
| **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 88,200,068.00 |
| ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 23,073,296.00 |
| Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 47,881,572.00 |
| Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 17,245,200.00 |
| **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

АУДИТЫН ТАЙЛАНГ:

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР: П.АМАРЖАРГАЛ

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР: А.ЦЭЭНЯМ

6417143544
БЮА0067 9007423